



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн
дүрмийг хүчингүйд тооцох, холбогдох
журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг үргэлжлүүлэн хангуулах тухай”-ын 3 дахь хэсэг ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06 тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын Үндэсний зөвлөл”-ийн дүрмийг хүчингүй болгосугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 474 тоот тогтоолоор баталсан Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журамд дараахи өөрчлөлт оруулсугай.

2.1 Журмын 2.1-т “компанийн засаглалын ахисан түвшний сургалт явуулах” гэж нэмсүгэй.

2.2 Журмын 2.5-т “Зөвлөл нь гэрээний үндсэн дээр сургалтын байгууллагаас тодорхой зохицуулалтын хөлс авч болно” гэж нэмсүгэй.

3. Холбогдох тогтоол, шийдвэрийг үндэслэн Компанийн засаглалын Үндэсний зөвлөлтэй “Хамтран ажиллах гэрээ” байгуулж ажилсугай.

Журамд өөрчлөлтийг оруулж хэрэгжилтийг хангуулж ажиллахыг ажлын алба /Ц.Нацагдорж/-нд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ДЭД ДАРГА

Э.БАТБОЛД

